3.	Арга хэмжээ 3.6.2. Хот төлөвлөх, хот байгуулах үйл ажиллагаанд мөрддөг стандартыг хангуулж, барилга байгууламжийн загвар зургийн иж бүрдэлд хотын стандартын шаардлагыг тусгахад чиг үүргийн хүрээнд хамтран ажиллана.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	-	50	Хотын стандартын хэрэгжилтийг хангуулах хүрээнд барилга, байгууламжийн загвар зурагт дараах нэмэлт өөрчлөлт оруулан, Загвар зургийн үндсэн шаардлага, үлгэрчилсэн загварт нэмэлт өөрчлөлт оруулах тухай тушаалын төсөлд санал өгөв. Үүнд: - тохижилт ногоон байгууламж; - замын хөдөлгөөн; - хүүхдийн тоглоомын талбай; - барилгын түр хашаа, хөгжлийн бэрхшээлтэй хүний хүртээмж.	01-12	70

1	2	3	4	5	6	7	8
4.	Арга хэмжээ 3.6.3. Батлагдсан хотын стандартын чиглэлээр түүнийг мөрдүүлэх сургалт арга зүйгээр хангах, зөвлөн туслах арга хэмжээг зохион байгуулж, үр дүнг тайлагнахад чиг үүргийн хүрээнд хамтран ажиллана.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	50	Баянгол дүүргийн Засаг даргын Тамгын газраас ирүүлсэн хүсэлтийн дагуу тус дүүргийн худалдаа үйлчилгээ болон хоол үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэгч байгууллагын нийт 150 гаруй төлөөлөлд "UCS 1202B:2022 Худалдаа, үйлчилгээний газрын гадна сурталчилгааны байгууламжид тавих ерөнхий шаардлага" хотын стандартын 3 удаагийн сэдэвчилсэн сургалтыг зохион байгуулж, зөвлөмж өгч хамтран ажиллалаа. Газрын даргын 2025 оны 05 сарын 06-ны өдөр батлагдсан сургалтын төлөвлөгөөний дагуу дараах ажлыг хийж гүйцэтгэв. Үүнд: - "Хотын стандарт, түүний хэрэгжилт, 3 дугаар ээлжийн хотын стандартын танилцуулга" сэдвээр Налайх дүүргийн Засаг даргын тамгын газар, засаг даргын дэргэдэх хэлтэс, харьяа байгууллагын 50 гаруй албан хаагчдад 2025 оны 05 сарын 23-ны өдөр сургалт зохион байгуулав. - "UCS 1204B:2025 "Хүүхдийн зуслангийн гадна орчинд тавигдах шаардлага" хотын стандартын сэдэвчилсэн сургалтыг Нийслэлийн эрүүл мэндийн газартай хамтран хүүхдийн зуслангийн үйл ажиллагаа эрхлэгч байгууллагын 30 орчим төлөөлөлд 2025 оны 05 сарын 30-ны өдөр сургалт зохион байгуулж ажиллаа. Налайх дүүргийн Засаг даргын Тамгын газраас ирүүлсэн хүсэлтийн дагуу тус	01-12	100

1	2	3	4	5	6	7	8
					дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй аялал жуулчлал, зочид буудал, амралтын газруудын 100 орчим удирдах ажилтнуудад “UCS 1203B:2022 Амралтын газар, жуулчны баазын гадна болон дотор орчны тохижилт, зохион байгуулалтад тавих ерөнхий шаардлага” хотын стандартын сэдэвчилсэн сургалтыг зохион байгуулж, зөвлөмж өгч хамтран ажиллалаа. Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/237 дугаар захирамж, Улаанбаатар хотын ерөнхий менежерийн А/31 дүгээр тушаалын дагуу Налайх дүүрэгт хууль, тогтоомж, стандартын хэрэгжилт, орчны аюулгүй байдлыг хангуулахаар ажиллаж нийт 43 зөрчлийг илрүүлж ажиллав. UCS 1203B:2022 “Амралтын газар, жуулчны баазын гадна болон дотоод орчны тохижилт, зохион байгуулалтад тавих ерөнхий шаардлага” хотын стандартын зөвлөмж хуудсыг Нийслэлийн аялал жуулчлалын газарт 01/341 дугаартай албан бичгээр хүргүүлж ажиллаа.		
5.	Арга хэмжээ 3.6.4. Хотын стандарт, тэдгээрийг мөрдүүлэх талаар мэдээ бэлтгэж, цахим хуудсаар дамжуулан иргэн, хуулийн этгээдэд түгээх	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	50	Хотын стандартыг мөрдүүлэх олон нийтэд сурталчлан таниулах чиглэлээр дараах 5 бүлгийн нийт 12 богино хэмжээний видео контентыг бэлтгэж, байгууллагын цахим хуудсаар дамжуулан иргэн, хуулийн этгээдэд түгээн ажиллаж байна. Үүнд: 1. Нийтийн эзэмшлийн эд хөрөнгө; 2. Ногоон байгууламж; 3. Нийгмийн дэд бүтэц; 4. Хог хаягдлын менежмент;	01-12	100

1	2	3	4	5	6	7	8
					5. Худалдаа үйлчилгээний гадна орчин. Баянгол дүүргийн худалдаа үйлчилгээ эрхлэгч байгууллагын төлөөлөлд "UCS 1202B:2022 Худалдаа, үйлчилгээний газрын гадна сурталчилгааны байгууламжид тавих ерөнхий шаардлага" хотын стандартын сэдэвчилсэн сургалт орж, зөвлөмж өгч ажилласан талаарх мэдээллийг 2025 оны 04 дүгээр сарын 11-ний өдөр байгууллагын болон тус дүүргийн цахим хуудсаар түгээж ажиллав. Хотын стандартыг мөрдүүлэх ажлын хүрээнд "UCS 1203B:2022 Амралтын газар, жуулчны баазын гадна болон дотор орчны тохижилт, зохион байгуулалтад тавих ерөнхий шаардлага" стандартын зөвлөмж хуудас бэлтгэж Налайх дүүргийн цахим хуудсаар нийтэлж олон нийтэд түгээв. Батлагдсан хотын стандартыг байгууллагын үйл ажиллагаанд хэрэгжүүлэн, олон нийтэд сурталчлан таниулах чиглэлд хамтран ажиллах талаар "Юнител групп"-д 02/68 дугаартай албан бичиг хүргүүлэв. "Улаанбаатар мэдээ" цахим хуудсанд "UCS 0301B:2022 Барилга, замын ажил гүйцэтгэхэд иргэдийн аюулгүй байдлыг хангах ерөнхий шаардлага" хотын стандартын талаар ярилцлага өгч ажиллав.		

1	2	3	4	5	6	7	8
6.	Арга хэмжээ 3.6.5. Худалдаа, үйлчилгээний чиглэлээр боловсруулсан хотын стандартын төслүүдийг боловсронгуй болгож, удирдлагад танилцуулах.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	Боловсруулсан хотын стандартын төсөл	50	Худалдаа, үйлчилгээний чиглэлээр боловсруулсан дараах 3 хотын стандартын төслүүдийг боловсронгуй болгож удирдлагад танилцуулахаар бэлтгэл ажил хангуулж байна. Үүнд: 1. Дахивар нөөц авах цэгт тавигдах шаардлага; 2. Авто засварын газрын гадна орчинд тавигдах ерөнхий шаардлага; 3. Автомашин угаалгын газарт тавигдах ерөнхий шаардлага.	01-12	70
Зорилт 3.10. Нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх хүрээнд							
1.	Арга хэмжээ 3.10.1. Хотын стандарт, тэдгээрийг мөрдүүлэх талаар зөвлөмж, мэдээ бэлтгэн олон нийтийн цахим сүлжээгээр нийтэлнэ.	Олон нийтэд мэдээлсэн тоо	-	1	Баянгол дүүргийн худалдаа үйлчилгээ эрхлэгч байгууллагын төлөөлөлд "UCS 1202B:2022 Худалдаа, үйлчилгээний газрын гадна сурталчилгааны байгууламжид тавих ерөнхий шаардлага" хотын стандартын сэдэвчилсэн сургалт орж, зөвлөмж өгч ажилласан талаарх мэдээллийг байгууллагын болон тус дүүргийн цахим хуудсаар түгээж ажиллав. Хотын стандартыг мөрдүүлэх ажлын хүрээнд "UCS 1203B:2022 Амралтын газар, жуулчны баазын гадна болон дотор орчны тохижилт, зохион байгуулалтад тавих ерөнхий шаардлага" стандартын зөвлөмж хуудас бэлтгэж Налайх дүүргийн цахим хуудсаар нийтэлж олон нийтэд түгээв.	01-12	100
2.	Арга хэмжээ 3.10.2. Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	50	2024 оны Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг 2025 оны 01 дүгээр сард багтаан гаргаж баталгааны хуудсаа Захиргаа удирдлагын хэлтэст хүргүүлэн ажиллав.	01-12	100

1	2	3	4	5	6	7	8
	тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах						
3.	Арга хэмжээ 3.10.3. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд (2024-2030) 2025 онд хэрэгжүүлэхээр тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэхэд чиг үүргийн хүрээнд хамтран ажиллах	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	50	Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийг хангуулж ажиллаж Хот байгуулалт, хотын стандартын газрын 2025 оны Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган хагас жилээр тайлагнаж хамтран ажиллав.	01-12	100
4.	Арга хэмжээ 3.10.4.“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд хавар, намрын улиралд мод тарих ажилд оролцоно.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	50	“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн, “Ногоон хот-Иргэний оролцоо” хаврын мод тарих өдрийг тохиолдуулан 05 дугаар сарын 16-ны өдөр Хан-Уул дүүргийн 14 дүгээр хорооны нутаг дэвсгэр, Айцын аманд модны арчилгаа, нөхөн тарилтын ажлыг хийж гүйцэтгэв. Нийтлэг үйлчилгээний газраас зохион байгуулсан Нутгийн захиргааны төв байгууллагын гадна талбайд мод тарих, зүлэгжүүлэх ажлыг хийх хүрээнд “Нэг албан хаагч-нэг мод” аянд хандив өгч ажиллав.	05-11	100
5.	Арга хэмжээ 3.10.5. Иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд нь шийдвэрлэн ажиллана.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	50	Тайлант хугацаанд EDOC цахим системээр иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн 3 өргөдөл, гомдол, 5 албан бичгийг хуулийн хугацаанд бүрэн шийдвэрлэн ажиллалаа.	01-12	100

1	2	3	4	5	6	7	8
6.	Арга хэмжээ 3.10.6. Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу 2024 оны үйл ажиллагааны явцад үүссэн баримтыг холбогдох журмын дагуу архивд хүлээлгэн өгөхөд хамтран ажиллана.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	100	Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу Хэлтсийн 2024 оны батлагдсан хотын стандартыг сурталчлан таниулах ажлын хүрээнд боловсруулагдсан хэвлэлийн мэдээ, зөвлөмжийн хуудсыг архивлан, дотоод товъёгийг бүрдүүлэн архивын мэргэжилтэнд хүлээлгэн өгөв.	01-03	100
Зорилт 4.1. Газраас үзүүлж буй үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, шуурхай, чирэгдэлгүй байх нөхцөлийг бүрдүүлэн, үр дүнг нэмэгдүүлнэ.							
1.	Арга хэмжээ 4.1.1 Газраас үзүүлж буй үйлчилгээг иргэдэд шуурхай хүргэж, мэдээллийн ил тод байдлыг хангаж чиг үүргийн хүрээнд хамтран ажиллана.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	50	Нэгжийн чиг үүргийн дагуу хотын стандартын талаар иргэд олон нийтэд цаг тухай бүр мэдээлэл өгч ажиллаж байна. Хотын стандартыг мөрдүүлэх олон нийтэд сурталчлан таниулах чиглэлээр дараах 5 бүлгийн нийт 12 богино хэмжээний видео контентыг бэлтгэж, байгууллагын цахим хуудсаар дамжуулан иргэн, хуулийн этгээдэд түгээн ажиллаж байна. Үүнд: 1. Нийтийн эзэмшлийн эд хөрөнгө; 2. Ногоон байгууламж; 3. Нийгмийн дэд бүтэц; 4. Хог хаягдлын менежмент; 5. Худалдаа үйлчилгээний гадна орчин.	01-12	70

Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
1	2	3	4	5	6	7	8
1.	Газрын даргын А/09 дугаар тушаалын хэрэгжилт	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	-	100	Газрын даргын 2025 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн А/09 дугаар тушаалын дагуу Спорт хамтлагийн гишүүнээр ажиллаж тэмцээн уралдаан зохион байгуулахад хамтран оролцож байна.	01-12	100

Хоёр. Мэдлэг чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээ

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
1	2	3	4	5	6	7	8
1.	Арга хэмжээ 1. Төрийн албаны зөвлөл, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар болон газрын хэмжээнд зохион байгуулсан сургалтад хамрагдана.	Сургалтад хамрагдсан цаг	65	35	Тайлант хугацаанд нийт 35 цагийн дараах сургалтуудад хамрагдав. Үүнд: - Захиргаа удирдлагын хэлтсээс зохион байгуулсан ХАСХОМ шинэчлэгдсэн заавар, маягт сургалт /2 цаг/ - Авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан 2024 оны Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон Хөрөнгө, орлогын мэдүүлэг шинэчлэн гаргах тухай /2 цаг/ - Захиргаа удирдлагын хэлтсээс зохион байгуулсан Монгол бичгийн анхан шатны мэдлэг олгох сургалт /3цаг/	01-12	100


1	2	3	4	5	6	7	8
					- Хуулийн хэлтсээс зохион байгуулсан 2025 оноос мөрдөгдөж эхлэх хууль тогтоомжийн талаарх мэдээллийн цаг /2цаг/ - Улаанбаатар хотын тогтвортой авто зам, тээвэр төслийн зөвлөх багаас зохион байгуулсан Хотын гудамж замын хурд түүнээс хамаарч ямар эрсдэл бий болдог хот байгуулалтын бодлогын хүрээнд юуг анхаарч үзэх шаардлагатай байгаа талаарх сургалт /2цаг/ - Нийслэлийн Засаг даргын Тамгын Газраас зохион байгуулсан “Захиргааны шийдвэр ба хүний эрх, Нийслэлийн нутаг дэвсгэрт худалдаа, үйлчилгээ эрхлэх нийтлэг журмын талаар ойлголт, хэрэгжилтийг хангах” сургалт /8 цаг/ - Нийслэлийн Засаг даргын Тамгын Газраас зохион байгуулсан АНУ-ын Rotomac их сургуулийн декан, доктор Сергей Андрониковын GIS ба Ухаалаг хот сургалт /2цаг/ - “Тав Ди Ворлд” ХХК-аас зохион байгуулсан CHCNAY X500 дрон, AA10 лидар болон RS10 лидарийн дэлгэрэнгүй танилцуулах сургалтад хамрагдав. /2 цаг/ - Нэгжүүдийн хуваарийн дагуу явагдсан Мэдээллийн цаг сургалт /12 цаг /		
2.	Арга хэмжээ 2. ArcGis газар зүйн мэдээллийн системийн анхан шатны мэдэгдэхүүнтэй болох	Анхан шатны мэдлэгтэй болсон байна.	-	-	Тайлант хугацаанд хийж хэрэгжүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.	06-12	-

1	2	3	4	5	6	7	8
3.	Арга хэмжээ 3. Photoshop программын анхан шатны сургалтад хамрагдана.	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	50	"Zangia academy"-ийн Photoshop программын анхан шатны сургалтад нийт 3 цагийн 12 бүлэг сургалтад хамрагдав.	01-12	70

ТАЙЛАН ГАРГАСАН:

ХУДАЛДАА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БАЙГУУЛЛАГЫН
СТАНДАРТ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

(Албан тушаал)



..... /Т.БОЛОРЧИМЭГ/

(Нэр, гарын үсэг)

2025.06.10.

(Огноо)

ХОТЫН СТАНДАРТ, ХӨГЖЛИЙН ХЭЛТСИЙН 2025 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН
ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТАЙЛАН

2025 оны 05 дугаар сарын 30

Улаанбаатар хот

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин		Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэл хувь
					Эхний хагас жил	Сүүлийн хагас жил		
1	2	3	4	5	6	7	8	9
ЗОРИЛГО 2. БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД:								
УЛААНБААТАР "20 МИНУТЫН ХОТ"								
Зорилт 2.1. Хот байгуулалтын болон холбогдох салбарын хууль, журам, норм, дүрэм, стандартын хэрэгжилтэд нэгдсэн дүн шинжилгээ хийж, эрх зүйн орчныг сайжруулна. (ЗГҮАХ -1.1, НХТЖҮЧ- 9.1, НЗДҮАХ-ийн – 1.1.1)								
1.	2.1.1.Хот байгуулалт болон холбогдох салбарын хууль, журам, норм, дүрэм, стандартын хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж өөрчлөлт оруулах тухай саналыг холбогдох газарт хүргүүлнэ.	-	Саналын тоо	-	1	-	Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн шинэчлэн найруулах ажлын хүрээнд: - Засгийн газрын тохируулагч агентлаг Стандарт, хэмжил зүйн газар, Шадар сайдын ажлын албатай 2025 оны 02 дугаар сарын 10-ны өдөр хамтарсан уулзалтад оролцон хотын стандартын эрх, зүйн орчинг сайжруулах, Захиргааны ерөнхий хуультай уялдуулах талаар саналаа өгсөн. Үүнд: 4.1.3. "хотын стандарт" гэж иргэдийн эрүүл аюулгүй тав тухтай орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэсэн ерөнхий	100

							шаардлага, үзүүлэлтийг сонирхогч талууд зөвшилцөн боловсруулж баталсан нийслэлийн хэмжээнд дагаж мөрдөх баримт бичиг – гэж; 10¹.1. Хотын удирдлагаас иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах чиг үүргийнхээ хүрээнд батласан стандартыг нийслэлийн хэмжээнд даган мөрдөж болно -- гэж нэмэлт өөрчлөлт оруулах. - Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам, Стандарт, хэмжил зүйн газраас 2025 оны 02 дугаар сарын 19, 21-ний өдөр зохион байгуулсан “Барилгын салбарын стандартын өнөөгийн байдалд тулгамдаж буй асуудал” нээлттэй хэлэлцүүлэгт оролцож, Хотын стандартын хэрэгжилт, тулгамдаж буй асуудал сэдвийн хүрээнд танилцуулга, илтгэл бэлтгэж газрын даргад танилцууллаа.	
2.	2.1.2.Хотын стандартыг хот байгуулалт болон холбогдох салбарын хууль, журам, норм, дүрэм, стандартад нийцсэн талаарх үзлэг, судалгаа хийнэ.		Судалгаа тайлан	-	-	1	Газрын даргын 2024 оны А/79 дүгээр “Ажлын хэсэг байгуулах” тухай тушаалын хүрээнд: Хотын стандартыг холбогдох салбарын хууль, журам, норм, дүрэмтэй нийцсэн эсэх талаарх саналыг авч нэгтгэлээ. Үүнд: - Газрын нийт алба, хэлтсүүдээс ирүүлсэн БНБД-тэй холбоотой 14 саналыг нэгтгэж ажлын хэсэгт танилцуулсан. - Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам, Боловсрол яам, Барилгын хөгжлийн төв болон Нийслэлийн нутгийн захиргааны 31 байгууллагуудад нийслэлийн хэмжээнд хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хотын стандарт, салбарын хууль, тогтоомжид нийцэж буй эсэх талаар санал авахаар 2025 оны 01/392, 01/393 дугаартай албан бичгийг	70

							- хүргүүлсэн. Тус албан бичгийн дагуу 9 байгууллагаас 30 санал ирсэн. Үүнд: • Ерөнхий санал -8 • Тухайлсан санал -- 22 Дээрх саналуудад дүн шинжилгээ хийж, Газрын даргад танилцуулсан. Хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа 52 хотын стандартад чиг үүргийн дагуу үзлэг судалгааг хийж байна.	
Зорилт 2.9. Иргэдийн амьдрах орчны хүртээмжийг хангахад чиглэсэн хотын стандартыг батлан мөрдүүлнэ. (НХТЖҮЧ-9.5, НЗДҮАХ-ийн -- 1.2.11)								
3.	2.9.1."Орон сууцны хороолол дахь ногоон байгууламж" хотын стандартын төслийг боловсруулна.		Хотын стандартын төсөл	Суурь судалгаа	-	1	Газрын даргаар 2025 оны 06 дугаар сарын 05-ны өдөр "Орон сууцны хороолол дахь ногоон байгууламж" хотын стандартын ажлын даалгаврыг батлуулсан. (НЗДТГ-ын Хөгжлийн бодлого төлөвлөлтийн газарт тус ажлын хөрөнгө оруулалтын саналыг нийслэлийн 2025 оны төсөвт суулгуулахаар саналаа хүргүүлсэн боловч хөрөнгө тусгаагдаагүй)	50
4.	2.9.2."Эрчим хүчний хэмнэлттэй амины орон сууцны жишиг зураг төсөл" хотын стандартыг эрх бүхий байгууллагаар батлуулж, хэрэгжилтийг хангуулна.	-	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	Хотын стандартын төсөл боловсруулсан	50	50	Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 25/07 дугаар тогтоолоор UCS1101C:2025 "Эрчим хүчний хэмнэлттэй амины орон сууцны жишиг зураг төсөл" хотын стандартыг батлуулав. Тус хотын стандартыг иргэд, олон нийтэд сурталчлан таниулах ажлын хүрээнд "Монголын амины орон сууцны инновац хөгжлийн төв"-ийн удирдлагатай 2025 оны 05 дугаар сарын 25-ны өдөр уулзалт зохион байгуулсан. Уулзалтаар цаашид хамтран ажиллах төлөвлөгөө гарган, ажиллахаар болсон.	100
5.	2.9.3.Гадна тохижилтын ажилд хамаарах хотын стандартыг мөрдүүлнэ.		Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	Батлагдсан хотын стандарт 2	50	50	1. Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/237 дугаар захирамж, Улаанбаатар хотын ерөнхий менежерийн А/31 дүгээр "Хууль, тогтоомж, стандартыг хэрэгжилт, орчны аюулгүй байдлыг хангуулах" тушаалын дагуу нийслэлийн 9 дүүргийн хэмжээнд 591 зөрчлийг орон зайн мэдээллийн санд /Qfield/ бүртгэж, иргэдийг эрүүл, аюулгүй, орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэсэн	100

							хотын стандартыг мөрдлөг болгон ажиллах 110 зөвлөмжийг иргэн, хуулийн этгээдэд өгч ажиллав. 2. Хотын стандартын хэрэгжилтийг хангуулах хүрээнд батлагдсан 16 бүлэг 68 хотын стандартын жагсаалт болон хүчин төгөлдөр мөрдөгдөж буй 16 хотын стандартын зөвлөмжийн хуудсыг нийслэлийн 9 дүүргийн Засаг даргын Тамгын газарт 2025 оны 01/30 дугаар албан бичгээр хүргүүлэв. 3. Хотын стандартын талаарх мэдлэг ойголтыг дээшлүүлэх, сурталчлан таниулах хүрээнд "Хотын стандарт"-ын сэдэвчилсэн сургалт зохион байгуулах төлөвлөгөө боловсруулж 2025 оны 05 дугаар сарын 06-ны өдөр газрын удирдлагаар батлуулав. Батлагдсан төлөвлөгөөний дагуу Нийслэлийн 9 дүүргийн Засаг даргын Тамгын газрын 162 албан хаагч, 297 иргэн, хуулийн этгээдэд хотын стандартын сэдэвчилсэн сургалт орж арга зүйгээр ханган ажиллав. 4. Нийслэлийн Засаг даргын тамгын газрын даргын 2024 оны А/108 дугаар тушаал "Нийслэл Улаанбаатар хотын нутаг дэвсгэр дэх нийтийн эзэмшлийн байгууламж, зам, гудамж, талбай, гэрэл дохио, гэрэлтүүлэг болон хөдөлгөөнгүй бусад хэрэгслийн тусламжтайгаар байрших зар сурталчилгаа байрлуулах тусгай зөвшөөрөл олгох, хугацааг сунгах, хүчингүй болгох асуудлаар дүгнэлт гаргаж танилцуулах, шийдвэрлүүлэх үүрэг бүхий Ажлын хэсэг"-ийн бүрэлдэхүүнд орон, зар сурталчилгааны самбар байрлуулах зөвшөөрөл хүссэн иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн нийт 74 хүсэлтэд Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 22-р тогтоолоор батлагдсан UCS 1202В:2022 "Худалдаа үйлчилгээний газрын гадна сурталчилгааны байгууламжид тавигдах ерөнхий шаардлага", UCS 1403В:2022 "Гадна	
--	--	--	--	--	--	--	--	--

							мэдээллийн байгууламжид тавигдах ерөнхий шаардлага” хотын стандартад нийцүүлэх талаар арга зүйгээр ханган ажиллаж байна.	
6.	2.9.4.Нийгмийн дэд бүтцэд хамаарах батлагдсан хотын стандартыг мөрдүүлнэ.		Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	Батлагдсан хотын стандарт	50	50	1. Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 19 дүгээр тогтоолоор батлагдсан Нийгмийн дэд бүтэц бүлгийн дараах 3 хотын стандартын зөвлөмжийн хуудсыг бэлтгэн, “Хотын стандартын хэрэгжилтийг хангуулан хамтран ажиллах тухай” 2025 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн 01/301 дугаартай албан бичгийг Нийслэлийн 9 дүүргийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэв. Үүнд: • UCS 1103B:2022 “Эрүүл мэндийн байгууллагын гадна орчны ерөнхий шаардлага”; • UCS 1101B:2022 “Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын гадна орчны ерөнхий шаардлага” • UCS 1102B “Ерөнхий боловсролын сургуулийн гадна орчинд тавих ерөнхий шаардлага”. 2. Багахангай дүүргийн Засаг даргын Тамгын газраас ирүүлсэн 2025 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн 08/266 дугаартай албан бичгийн хүрээнд хотын стандартыг батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах журам, 16 бүлгийн 68 хотын стандартын талаарх танилцуулга, Нийгмийн дэд бүтэц бүлгийн хотын стандартын сэдэвчилсэн сургалтыг 2025 оны 04 дүгээр сарын 08-ны өдөр зохион байгуулж Багахангай дүүргийн Засаг даргын Тамгын газрын 30 албан хаагчид сургалт орж арга зүйгээр ханган ажиллав. 3. Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 25/07 дугаар тогтоолоор батлагдсан “Эрчим хүчний хэмнэлттэй амины орон сууцны жишиг зураг төсөл” хотын стандартыг	100

							сурталчлан таниулах, хэрэгжилтийг хангуулах ажлын хүрээнд "Монголын амины орон сууцны инновац хөгжлийн төв"-тэй 2025 оны 05 дугаар сарын 25-ны өдөр уулзалт зохион байгуулан хамтран ажиллах төлөвлөгөө боловсруулан бэлтгэл арга хэмжээг ханган ажиллаж байна.	
7.	2.9.5."Нийслэл Улаанбаатар хотын 2040 оны хөгжлийн ерөнхий төлөвлөгөө"-г хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу өнөөгийн нөхцөл байдалд суурь, судалгаа хийнэ.		Судалгааны тайлан	-	-	1	Улаанбаатар хотын 2040 оны хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний 11.1-т Сэргээгдэх эрчим хүчний хангамж бүлгийн Сэргээгдэх эрчим хүчний эзлэх хувийг 30%-д хүргэх зорилтын хүрээнд Эрчим хүчний үр ашигтай хэрэглээг бий болгож ногоон хөгжлийн бодлогыг дэмжих зорилгоор гэр хорооллын амины орон сууцыг эрчим хүчний хэмнэлтэй болгох суурийг бүрдүүлэн 2022 оноос судалгаа хийн, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 25/07 дугаар тогтоолоор "UCS1101C:2025 Эрчим хүчний хэмнэлттэй амины орон сууцны жишиг зураг төсөл" хотын стандартыг батлуулав.	100
Зорилт 2.29. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг нийгмийн харилцаанд тэгш, хүртээмжтэй оролцох боломжийг нэмэгдүүлж, барилга байгууламж, явган хүний зам, гэрлэн дохиог олон улсын стандартад нийцүүлэн өөрчилнө. (ЗГҮАХ-1.1.5.2, НЗДҮАХ-ийн – 1.4, НЗДҮАХХАХТ-2.3.2)								
8.	2.29.1.Хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй дэд бүтэц бүлгийн хотын стандартуудыг мөрдүүлж хүртээмжтэй байдлыг нэмэгдүүлэх арга хэмжээг зохион байгуулна.		Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	Батлагдсан хотын стандарт 2	50	50	1. Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/237 дугаар захирамж, Улаанбаатар хотын ерөнхий менежерийн А/31 дүгээр тушаалын дагуу хууль, тогтоомж, стандартын хэрэгжилт, орчны аюулгүй байдлыг хангуулахаар 9 дүүрэгт хийгдэж байгаа явган хүний зам, талбайн тохижилтын ажилд НИТХ-ын 2023 оны 42-р тогтоолоор батлагдсан "Хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй дэд бүтэц" бүлэгт хамаарах хотын стандартын зөвлөмж хуудсыг боловсруулан 9 дүүргийн Засаг даргын Тамгын газарт 2025 оны 01/301 дугаар албан бичгээр хүргүүлж, Багахангай дүүргийн Хангай цогцолбор сургуулийн налуу замыг шинэчлэх ажилд зөвлөмж өгч, хөгжлийн бэрхшээлтэй хүний хүртээмжтэй байдлыг хангаж ажиллав.	70

						2. 2025 онд нийслэлийн хэмжээнд төсвийн хөрөнгөөр хэрэгжих тохижилт бүтээн байгуулалтын ажлыг хотын стандартын шаардлагад нийцүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй хүний хүртээмжтэй байдлыг хангуулах хүрээнд Зөвлөн туслах арга хэмжээ зохион байгуулахаар төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна. 3. Монгол улсын хүний эрхийн үндэсний комиссын зөвлөмжийн биелэлт, хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй дэд бүтэц бүлгийн хотын стандартуудыг мөрдүүлэх, арга хэмжээний саналыг бэлтгэн 2025 оны 02 дугаар сарын 19-ны өдөр Захиргаа удирдлагын хэлтэст хүргүүлэв.	
9.	2.29.2. Агаар, орчны бохирдуулагч эх үүсвэрийг бууруулах хүрээнд дуу чимээний бохирдол бүлгийн хотын стандартыг мөрдүүлж, асуудал хариуцсан чиг үүргийн нутгийн захиргааны байгууллагатай хамтран ажиллана.		Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	Батлагдсан 2 хотын стандарт, Агаарын чанарын суурь судалгаа	50	Агаар, орчны бохирдуулагч эх үүсвэрийг бууруулах хүрээнд дараах ажлыг хийж хэрэгжүүлсэн. Үүнд: - Нийслэлийн Агаар, орчны бохирдолтой тэмцэх газрын холбогдох албан хаагчидтай 2025 оны 02 дугаар сарын 14-ний өдөр уулзалт хийж хотын стандарт боловсруулах аргачилсан заавар, зөвлөмж өгч, чиг үүргийн хүрээнд батлагдсан хотын стандартыг мөрдүүлэх чиглэлээр хамтран ажиллахаар санал солилцлоо. - Энэ хүрээнд 2023 онд батлагдсан "Дуу чимээний бохирдол" бүлгийн 3 хотын стандартын баримт бичиг болон хураангуй зөвлөмжийг хүргүүлж хамтран ажиллалаа. Нийслэлийн Засаг даргын 2024 оны "Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай" А/1541 дүгээр захирамж, Нийслэлийн Засаг даргын 2025 оны "Агаар бохирдуулагч эх үүсвэрийн судалгаа гаргах, хяналт шалгалт зохион байгуулах тухай" А/33 дугаар захирамжийн дагуу 2025 оны 01 дүгээр сарын 18, 19-ний өдрүүдэд Баянзүрх дүүргийн 31	70

							дүгээр хорооны нийт 62 айл, өрхийн зуухны галлагаа, угаарын хийн мэдрэгчийн хэвийн байдал зэрэгт үзлэг, судалгаа хийн ажлын хэсэгт хүргүүлэв.	
10.	2.29.3."Оршуулгын газрын орчны эрүүл, аюулгүй байдлын ерөнхий шаардлага" хотын стандартын хэрэгжилтийг хангуулна.		Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	Батлагдсан хотын стандарт 1	50	50	Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 25/05 дугаар тогтоолоор батлагдсан "UCS0302B:2025 Оршуулгын газрын орчны эрүүл, аюулгүй байдлын ерөнхий шаардлага" хотын стандартыг сурталчлан таниулах ажлын хүрээнд: - Оршуулгын үйлчилгээ эрхлэгч байгууллагуудад сурталчлан таниулах зорилгоор Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба болон Буяны зан үйлийн холбоонд хотын стандартын баримт бичгийг бүрэн эхээр 03 дугаар сарын 25-ны өдрийн 01/314 тоот албан бичгээр хүргүүлж ажиллалаа. - Оршуулгын үйлчилгээ эрхлэгч нарт 2025 оны 05 дугаар сарын 29-ний өдөр хотын стандартын танилцуулга сургалтыг зохион байгууллаа. - Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2025 оны А/370 дугаар тушаалын дагуу ажлын хэсэг байгуулагдсан. Ажлын хэсэг НИТХ-ын 2024 оны 08 дугаар тогтоолоор батлагдсан "Оршуулгын үйл ажиллагаа эрхлэх, зохион байгуулах зөвшөөрөлтэй оршуулгын газар болон зөвшөөрөлгүй газар оршуулсан шарилыг шилжүүлэх журам"-ын хэрэгжилтэд 95 шалгуур үзүүлэлт боловсруулан, 19 оршуулгын газарт хяналт шалгалтыг хийсэн. Батлагдсан хотын стандартыг сурталчлан таниулсан. - Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2025 оны А/35 дугаар ажлын хэсгийн гишүүнээр ажиллаж нөөцгүй болсон оршуулгын газрыг нүүлгэн шилжүүлэхтэй	100

							холбоотой Улаанбаатар хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө 2040 -тэй уялдуулан санал өгсөн.	
ЗОРИЛГО 3. ХУУЛИАР ХҮЛЭЭХ ЧИГ ҮҮРГИЙН ХҮРЭЭНД:								
Зорилт 3.1. Газрын хөгжлийн зорилтыг хангах ажлын хүрээнд								
11	3.1.1.Газрын 2025-2028 оны стратеги төлөвлөгөөг боловсруулахад чиг үүргийн хүрээнд хамтран ажиллана.		Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	-	50	50	Засгийн газрын 2020 оны 216 дугаар тогтоолоор батлагдсан “СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ, БАТЛАХ,ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ ЖУРАМ”-д нийцүүлэн боловсруулан Газрын даргын 2025 оны А/15 дугаар тушаалаар байгуулсан байгууллагын 2024-2028 оны стратеги төлөвлөгөө боловсруулах ажлын хэсэгт хэлтсийн дүрмээр хүлээсэн чиг үүргийн дагуу оролцон ажиллаж байна.	100
12	3.1.2.Чанарын менежментийн тогтолцооны ISO 9001:2015 Олон Улсын стандартын сайжруулалтыг хийхэд хамтран ажиллана.		Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	50	50	ISO 9001:2015 Чанарын менежментийн тогтолцоо стандартыг хөгжүүлэх ажлын хүрээнд дараах ажлыг хийж гүйцэтгэв. Үүнд: - Чанарын багийн 2024 оны ажлын тайлан, 2025 оны ажлын төлөвлөгөөг боловсруулсан. - 2025 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн А/12 дугаар тушаалаар Удирдлагын дүн шинжилгээний журам, Үл тохирол болон залруулах арга хэмжээний журам боловсруулан батлуулав. - “Чанарын менежментийн тогтолцооны журам”, “Дотоод аудитын журам”-ын төслийг боловсруулан газрын даргаар батлуулахаар бэлтгэл арга хэмжээг ханган ажиллаж байна. - “MNS ISO 9001:2016 Чанарын менежментийн тогтолцоо-шаардлага” стандартын сургалтад албан хаагчдыг хамруулахаар сургалтын судалгаа гаргаж, сургалтад хамруулахаар бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. - Магадлах шатны аудитад бэлтгэн, сайжруулах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан батлуулж, шаардлагатай баримт бичиг, материалуудыг бэлтгэн ажиллаж байна.	70

13	3.1.3.Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/01 захирамж “Бүтээн байгуулалтын жил”-ийн хүрээнд хотын стандартын хэрэгжилтийг хангуулах		Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	100	50	50	1. Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/237 дугаар захирамж, Улаанбаатар хотын ерөнхий менежерийн А/31 дүгээр “Хууль, тогтоомж, стандартын хэрэгжилт, орчны аюулгүй байдлыг хангуулах” тушаалын дагуу нийслэлийн 9 дүүргийн хэмжээнд 591 зөрчлийг орон зайн мэдээллийн санд /Qfield/ бүртгэж, иргэдийг эрүүл, аюулгүй, орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэсэн хотын стандартыг мөрдлөг болгон ажиллах 110 зөвлөмжийг иргэн, хуулийн этгээдэд өгч ажиллав. 2. Хотын стандартын хэрэгжилтийг хангуулах хүрээнд батлагдсан 16 бүлэг 68 хотын стандартын жагсаалт болон хүчин төгөлдөр мөрдөгдөж буй 16 хотын стандартын зөвлөмжийн хуудсыг нийслэлийн 9 дүүргийн Засаг даргын Тамгын газарт 2025 оны 01/30 дугаар албан бичгээр хүргүүлэв. 3. Хотын стандартын талаарх мэдлэг ойголтыг дээшлүүлэх, сурталчилан таниулах хүрээнд “Хотын стандарт”-ын сэдэвчилсэн сургалт зохион байгуулах төлөвлөгөө боловсруулж 2025 оны 05 дугаар сарын 06-ны өдөр газрын даргаар батлуулав. Батлагдсан төлөвлөгөөний дагуу Нийслэлийн 9 дүүргийн Засаг даргын Тамгын газрын 162 албан хаагч, 297 иргэн, хуулийн этгээдэд хотын стандартын сэдэвчилсэн сургалт орж арга зүйгээр ханган ажиллав.	100
Зорилт 3.6. Хотын стандарт, норм дүрмийг боловсронгуй болгох ажлын хүрээнд								
14.	3.6.1. Чиг үүргийн хүрээний хотын стандартыг иргэн, хуулийн этгээдэд сурталчлан таниулж мөрдүүлсэн үр дүн, хэрэгжилтийн тайланг удирдлагад танилцуулна.	-	Боловсруулсан тайлан	-	50	50	Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн 25/04 дүгээр тогтоолоор батлагдсан “Хотын стандартыг боловсруулах, хэрэгжилтийг зохион байгуулах журам”-ын хүрээнд нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын чиг үүрэгт хамаарах хотын стандартын хэрэгжилтийн тайлан, мэдээг нэгтгэн дүн шинжилгээ хийхээр нийслэлийн нутгийн захиргааны 10 байгууллага болон	70

							нийслэлийн 9 дүүргийн Засаг даргын Тамгын газарт 2025 оны 01/552 дугаар албан бичгийг хүргүүлэн, ирүүлсэн мэдээг нэгтгэн ажиллаж байна.	
15.	3.6.2.Гуравдугаар ээлжийн 7 бүлгийн хотын стандартыг нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулах ажлыг зохион байгуулна.	-	Хотын стандартын тоо	52	68	-	Нийслэлийн хэмжээнд иргэдийн эрүүл, ая тухтай амьдрах орчныг бүрдүүлэхэд чиглэсэн III ээлжийн 7 бүлэг 16 хотын стандартын төслийг нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэх ажлыг зохион байгуулан 2025 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн ээлжит II хуралдаанаар батлуулав. Хотын стандартыг сурталчлан таниулах ажлын хүрээнд 2025 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн батлагдсан төлөвлөгөөний дагуу дараах 2 хотын стандартын танилцуулгыг холбогдох байгууллагуудад өгч ажиллав. Үүнд: - UCS0302B:2025 “Оршуулгын газрын орчны эрүүл, аюулгүй байдлын ерөнхий шаардлага” хотын стандарт; - UCS1204B:2025 “Хүүхдийн зуслангийн гадна орчинд тавигдах ерөнхий шаардлага” хотын стандарт.	100
16.	3.6.3.Хот төлөвлөх, хот байгуулах үйл ажиллагаанд мөрддөг стандартыг хангуулж, барилга байгууламжийн загвар зургийн иж бүрдэлд хотын стандартын шаардлагыг тусгана.	-	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	-	50	50	Барилга, байгууламжийн загвар зургийн дараах иж бүрдэлд хотын стандартыг тусгуулан, нэмэлт өөрчлөлт оруулан Газрын удирдлага болон Ерөнхий архитекторын ажлын албанд танилцуулсан. Үүнд: - Тохижилт ногоон байгууламж; - Хүүхдийн тоглоомын талбай; - Барилгын түр хашаа; - Хөгжлийн бэрхшээлтэй хүний хүртээмж. Загвар зургийн үндсэн шаардлага, үлгэрчилсэн загварт нэмэлт өөрчлөлт оруулах тухай тушаалын төсөл бэлтгэж, нэгжүүдээс дараах 4 загвар зургийн төсөлд санал авч ажиллав.	70

17.	3.6.4.Хотын стандартын цахим санг бүрдүүлж, иргэд олон нийтийн хүртээмжтэй байдлыг хангах	-	Хотын стандартын тоо	52	68	1. Хотын стандартын бүртгэл мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх, хөтлөх, стандарт, норм, дүрмийг мөрдүүлэхэд иргэн, хуулийн этгээдийг мэдээлэл, арга зүйгээр хангах, зөвлөн туслах, сурталчлан таниулах, байгууллагын дүрмээр хүлээсэн чиг үүргийг хэрэгжүүлэх хүрээнд www.uds.ub.gov.mn цахим хуудсын хөгжүүлэлтийг Хотын орон зайн мэдээлэл, технологийн хэлтэстэй хамтран батлагдсан 15 бүлэг 52 хотын стандартыг олон нийтэд түгээх, цахим санг бүрдүүлэн ажиллав. 2. Иргэд, олон нийтийн мэдлэг ойлголтыг дээшлүүлэх хүрээнд боловсруулсан дараах Хотын стандартын богино хэмжээний видео, контентыг "Хот байгуулалт, хотын стандартын газар"-ын фэйсбүүк цахим хуудсаар дамжуулан хүргэн ажиллаж байна. Үүнд: • UCS 0301B:2022 "Барилга, замын ажил гүйцэтгэхэд иргэдийн аюулгүй байдлыг хангах техникийн ерөнхий шаардлага" • UCS 1405B:2022 "Хүүхдийн тоглоомын талбайн ерөнхий шаардлага" • UCS 1202B:2022 "Худалдаа, үйлчилгээний газрын гадна сурталчилгааны байгууламжид тавих ерөнхий шаардлага"	100	
18.	3.6.5.Батлагдсан хотын стандартын чиглэлээр түүнийг мөрдүүлэх сургалт арга зүйгээр хангах, зөвлөн туслах арга хэмжээг зохион байгуулж, үр дүнг тайлагнах	-	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	100	50	50	1. Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/237 дугаар захирамж, Улаанбаатар хотын ерөнхий менежерийн А/31 дүгээр "Хууль, тогтоомж, стандартын хэрэгжилт, орчны аюулгүй байдлыг хангуулах" тушаалын дагуу нийслэлийн 9 дүүргийн хэмжээнд 591 зөрчлийг орон зайн мэдээллийн санд /Qfield/ бүртгэж, иргэдийг эрүүл, аюулгүй, орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэсэн хотын стандартыг мөрдлөг болгон ажиллах	100

[illegible]

21.	3.10.1.Бодлогын баримт бичиг болон хууль тогтоомж, шийдвэрийн хяналтад авсан заалтын хэрэгжилтийг ханган ажиллаж, тайлагнана.	-	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	100	50	50	Бодлогын баримт бичиг болон хууль тогтоомжийн биелэлтийг Бодлогын баримт бичиг, газрын үйл ажиллагааны хэрэгжилт хариуцсан ахлах мэргэжилтэнд тухай бүр тайлагнан ажиллаж байна.	100
22.	3.10.2.Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн дагуу байгууллагын үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг хангаж, цахим хуудсанд мэдээ байршуулж, олон нийтэд мэдээлэх	-	Олон нийтэд мэдээлсэн тоо	6	2	2	Хотын стандартыг мөрдүүлэхэд иргэн, хуулийн этгээдийг мэдээлэл, арга зүйгээр хангах зорилгоор 15 бүлэг 52 хотын стандартыг https://uds.ub.gov.mn/ веб сайтад байршуулж, хэвлэл мэдээллийн хэрэгслээр /MNB, монголын үндэсний радио, нийслэлийн мэдээ, UBS, Тэнгэр, NTV/ нийт 6 удаагийн ярилцлага өгч, сайтууд, газрын цахим хуудсанд нийт 10 мэдээ нийтлэн ажиллав.	100
23.	3.10.3.Засгийн газрын гишүүд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн хооронд Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх талаар байгуулсан гэрээний хэрэгжилтийг тайлагнана.	-	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	100	50	50	Засгийн газрын гишүүд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн хооронд Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх талаар байгуулсан гэрээний хэрэгжилтийг захиргаа удирдлагын хэлтэст тухай бүр тайлагнаж ажиллаж байна.	100
24.	3.10.4.Хотын хөгжлийн индексийн холбогдох шалгуур үзүүлэлтийн үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах хүрээнд холбогдох байгууллагуудтай хамтран ажиллана.	-	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	-	50	50	- Нийслэлийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд Хотын хөгжлийн индексийг тусган боловсруулах ажлын хэсэгт 2025 оны 03 дугаар сарын 11, 12-ны өдөр ажиллаж, чиг үүргийн дагуу санал хүргүүлж ажиллав. - Хотын хөгжлийн индексийн шалгуур үзүүлэлтийг дээшлүүлэх хүрээнд 2025 онд Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар батлуулсан 7 бүлгийн 16 хотын стандартуудыг Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудад төсвийн хөрөнгөөр хийгдэх тохижилт бүтээн байгуулалтын ажлуудад холбогдох хотын стандартыг мөрдүүлж, олон нийтэд	100

							сурталчлан, хэрэгжилтийг зохион байгуулан ажиллах талаар 01/301 тоот албан бичгээр хүргүүлэв.	
25.	3.10.5.Улс, нийслэлийн төсөв, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө болон бусад эх үүсвэрээр 2024 онд нийслэлд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, санхүүжилтийн үйл ажиллагааг хууль болон холбогдох журамд нийцүүлэн ил тод шуурхай, зохион байгуулж ажиллана.	-	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	100	50	100	Газрын даргын А/22 дугаар “Үнэлгээний хороо байгуулах тухай тушаалын дагуу Барилга” байгууламжид газар хөдлөлтийн тэсвэржилтийн үнэлгээ хийж, паспортжуулах ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлын үнэлгээний хорооны нарийн бичгийн даргаар ажиллаж, нийслэлд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, санхүүжилтийн үйл ажиллагааг хууль болон холбогдох журамд нийцүүлэн ил тод шуурхай, зохион байгуулж ажилласан.	100
26.	3.10.6.Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах	-	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	-	50	50	1. Авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах. авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх талаар Авлигатай тэмцэх газраас соён гэгээрүүлэх чиглэлээр бэлтгэсэн контентууд, зурагт хуудас, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар болон нутгийн захиргааны байгууллагуудын дотоод удирдлагын нэгдсэн системээр сурталчлан таниулсан мэдээ, мэдээлэлтэй танилцаж, түгээн, дэмжин ажиллав. 2. Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд www.meduuleg.iaac.mn цахим хуудсын маягтын дагуу бөглөн баталгааны хуудсыг эрх бүхий албан тушаалтанд гаргаж хүлээлгэн өгч ажиллав.	100
27.	3.10.7.Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд (2024-2030) 2025 онд хэрэгжүүлэхээр тусгагдсан арга хэмжээг	-	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	-	50	50	Авлигатай тэмцэх газар, Төрийн албаны зөвлөл, Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас зохион байгуулсан “Мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах эрх бүхий албан тушаалтнуудын сургалт”, “ХАСХОМ гаргах заавар”, “Авлигын эсрэг хуульд заасны дагуу УИХ-ын Хууль зүйн байнгын	100

[illegible]

32.	4.1.1.Газраас үзүүлж буй үйлчилгээг иргэдэд шуурхай хүргэж, мэдээллийн ил тод байдлыг хангаж ажиллана.	-	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	100	50	50	Хотын стандартыг мөрдүүлэхэд иргэн, хуулийн этгээдийг мэдээлэл, арга зүйгээр хангах зорилгоор 15 бүлэг 52 хотын стандартыг https://uds.ub.gov.mn/ веб сайтад байршуулж, хэвлэл мэдээллийн хэрэгслээр /MNB, монголын үндэсний радио, нийслэлийн мэдээ, UBS, Тэнгэр, NTV/ нийт 6 удаагийн ярилцлага өгч, сайтууд, газрын цахим хуудсанд нийт 10 мэдээ нийтлэн ажиллав. Газрын үйл ажиллагааг сурталчлах, газраас үзүүлж буй үйлчилгээний талаар иргэн, хуулийн этгээдэд зөвлөгөө, мэдээлэл өгөх "Бид иргэдээ сонсож шийднэ" уулзалтад хуваарийн дагуу оролцон, хотын стандартын талаар иргэдэд зөвлөгөө мэдээлэл өгч ажиллав.	100
-----	--	---	-----------------------------------	-----	----	----	---	-----

Төлөвлөгөөг үнэлсэн:

Төсвийн шууд захирагч

ХОТЫН БАЙГУУЛАЛТ, ХОТЫН СТАНДАРТЫН
ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
(албан тушаал)

(гарын үсэг)

/Г.БАЯРСАЙХАН/

(огноо)

Тэмдэг

Тайлагнасан:

ХОТЫН СТАНДАРТ, ХӨГЖЛИЙН
ХЭЛТСИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН
(албан тушаал)

Нэгжийн дарга

(гарын үсэг)



/Э.СУВД-ЭРДЭНЭ/

(огноо)